



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 03 өдөр

Дугаар

861

Хараат

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6, 49 дүгээр зүйлийн 49.2.10 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний 86 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн “Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх” ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: -Э.Баярмаа (2 дугаар багийн Засаг дарга)

Нарийн бичиг: -Б.Мөнхтогтох (Байгаль орчны мэргэжилтэн)

Гишүүд: -Г.Жаргалмаа (1 дүгээр багийн Засаг дарга)


-Ж.Чулуунтогтох (Нягтлан бодогч )

-М.Доржсүрэн (Нярав )

2. Гүйцэтгэлийн чанар үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч хүлээн авсан акт үйлдэж баталгаажуулахыг ажлын хэсгийн ахлагч (Э.Баярмаа)-д үүрэг болгосугай.

3. Ажил хүлээлцсэн акт холбогдох бичиг баримтыг үндэслэн Засаг даргын Тамгын газрын өмчид бүртгэхийг нягтлан бодогч (Ж.Чулуунтогтох) -д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  А.ЭРДЭНЭСАЙХАН



4823000106